

STUDIA FOLCLORICA  
FOLKLORE STUDIES  
<https://doi.org/10.5564/sf.v45i1.4811>

Tom. XLV

2024

fasc. 2

Жангарч Жуунай “Жангар”-ын  
зарим бүлгийн төгсгөл дэх хавсралтын  
сураг зангийг шинжлэх нь

Очирын ТАЙВАН\*  
БНХАУ, Шинжааны их сургуулийн  
Түүхийн хурээлэн

Received: Jun 17, 2024

Revised: Jul 20, 2024

Accepted: Aug, 17, 2024

**Хураангуй:** Жангарч Жуунай “Жангар”-ын зарим бүлгийн төгсгөлд бичсэн хавсралт сураг занги нь “Жангар”-ын уламжлал залгамжлалд маш чухал үнэ цэнтэй сураг зангийг хангаж байдаг боловч өнгөрсөнд энэ тухай нарийн судалгаа хийгдээгүйгээс болж, зарим эрдэмтэд хавсралт сураг зангийг утга агуулгын хувьд зориуд гуйвуулж, “жангарч гэсэн сайхан нэр ба эд мөнгөний ашиг тус олохын төлөө” зохиосон буюу эсвэл “Эзэн манширын эрдэнийн ширээ”-г “Жуунай зохиосон” гэж үзсээр ирэв. Гэтэл энэ бүхэн нь ямар ч баримт үгүй зүйл байж, Жуунай зохиосон бус, харин эртний уламжлалтай байсан гэдгийг гэрчилж, энэ нь соёл түүхийн өндөр үнэ цэнтэй сураг занги юм гэх үзэлтээ дэвшүүлэв.

**Түлхүүр үг:** Жангар, Жуунай, төгсгөл, хавсралт сураг занги.

Unveiling Tradition: Exploring the Information in  
Juunai’s Epic Jangar Manuscript

TAIVAN Ochir  
Institute of History, Shinjaan University, China

**Abstract:** Juunai’s Epic Jangar manuscripts have garnered significant attention from scholars across diverse perspectives. However, the detailed exploration of the appendixes accompanying Juunai’s chapters has been somewhat neglected, despite these appendixes holding profound significance in terms of tradition inheritance.

\* © О.Тайван  
Email: taiwen811@163.com

*This neglect has fuelled a prevailing one-sided perspective, suggesting that Juunai added these appendixes for financial and fame-driven motives, creating for wealth and renown seemingly out of nowhere. By delving meticulously into the manuscript appendixes, this paper challenges such claims, positing that they did not originate with Juunai and lack empirical evidence. Instead, it posits that these traditions, invaluable historical and cultural assets, have been handed down through generations.*

**Key words:** Epic Jangar, Juunai, conclusion, information.

Удиртгал

Олны мэдээлснээр, жангарч Жуунай бол бичигтэй жангарч байжээ. “Жангар”-ын зарим бүлгийн төгсгөлд хаанаас яаж сурсан, хэрхэн бичсэнээ тэмдэглэсэн сураг зангийг бид хавсралт дахь сураг занги хэмээн нэрлэж<sup>1</sup> байгаа юм. Иймэрхүү хавсралт дахь сураг занги нь “Жангар”-ын уламжлалд жангарч болон “Жангар”-ыг сударласан бичээчийн тухай үнэ цэнтэй чухал сураг зангийг хангасан байдаг. Гэтэл энэхүү хавсралтад байгаа сураг зангийн утга учрыг буруу ойлгож, “жангарч гэсэн сайхан нэр, эд мөнгөний ашиг тус олохын төлөө Ж.Жуунай эрдэмтэн сэхээтэн болон энгийн уншигчдыг хуурах зальт арга хэрэглэж, ‘Жангар’-г хуурамчаар зохион хэлж, түүндээ гэрч болгож хуурамч баримт зохиож байсан зальтай бичгийн хүн болох нь нотлогдож байна” гэх буюу “Ж.Жуунай энэхүү хулгайлж зохиосон хуурамч бүлгийнхээ эцэст хавсаргасан зүйл болно. Тэрхүү хавсралт зүйлдээ хүмүүсийг хуурах хуурамч баримт зохиож, 1945 оны үеэр нас барсан Өлзийт Гүздэйн нэрийг ашиглан, өөрийн өвөг аав Эрхэтэйн гар бичмэл бүлэг мөн гэж гэрчлэхийг оролдсон” (Эрдэнэбаяр 2010: 52) хэмээн түүний бичсэн “Жангар”-ыг “хуурамч Жангар” хэмээн үзжээ. Мөн зарим нь хавсралтад байгаа сураг зангийг нягталж үзэлгүйгээр “Эзэн Манширын эрдэнийн ширээг Жуунай зохиосон” гэж бичсээр ирэв. Одоо болтол жангарч Жуунай “Жангар”-ын бүлгийн төгсгөлд бичсэн хавсралтад байгаа сураг зангийн тухай тусгайлан шинжлэн судалсан зохиол байхгүй мөртөө түүний үнэн эсэхийг шалгаж үзсэн зүйл үгүй байна. Ийнхүү тус өгүүлэлд Жуунай “Жангар”-ын зарим бүлгийн төгсгөлд бичсэн хавсралтад байгаа сураг занги бичигдсэн “Жангар”-ын бүлэг, хавсралтад байгаа сураг зангид гарах хүмүүс, түүний үнэ цэн гэж гурван талаар өгүүлэхийг зорив.

Үндсэн хэсэг

1. Хавсралтад сураг занги бичигдсэн “Жангар”-ын бүлэг

Жангарч Жуунаигаас “Жангар”-ын зарим бүлгийн төгсгөлийн хавсралтад байгаа сураг занги бичиж үлдээсэн байдаг. Үүнд:

1. “Догшин хар Хянас араг улаан Хонгорыг бариулж аюул эдэлгээд, ашандаа алдар Жангарт баригдаж агт хүлэгт чирэгдсэн бүлэг”-т 1956 оны 11дүгээр сарын 10-нд Ж.Жуунай хуулбарлан бичсэн тус бүлгийн төгсгөлд

<sup>1</sup> Энэхүү хавсралтад байгаа сураг зангийг Жижэйн Эрдэнэбаяр “Жангарын тархац, түүний газар зүйн хэв шинжүүд” номдоо “Хавсралт зүйл” хэмээн нэрлэж, Бу.Мөнх “Ж.Жуунай “Жангар” судлал” номдоо “Хавсаргасан зүйл” хэмээн нэрлэжээ.

“Шишнээн Буурал хэлснийг шар ноёны тамгын бичээч Замадагийн бичсэн гар бичмэлээс салгав” (Зуланцэцэг, 2013) гэж тус бүлэг “Жангар”-ыг хэлэгч болон бичигчийн тухай мэдээг тушаасан байдаг.

2. “Хоёр настай Хошуун улаан хөл өргөж дайнд мордоод, Догшин цагаан хааныг доройтуулсан бүлэг”-ийн төгсгөлд “урд цагт Ховогсайрын Чин вангийн тамгын бичээч Өлзийт гүздэйн шавь болж байхдаа түүний сударчлан бичсэн ‘Жангар’-аас энэ бүлгийг сурчээ” (Жангарын эх материал, 1988: 745) гэж хаанаас сурснаа тодорхой бичжээ.

3. “Алдар ноён Жангар хаан алтай зуугийн арслангийн тамгаа Хошуун улаанд өргөмжилсөн бүлэг”-ийн төгсгөлд “Ховогсайрын хуучин торгуудын алдартай жангарч нар Цагаан гэгээний өлмийн дэргэд олон өдөр шөнө ‘Жангар’ хэлж байгаад, одоо ямар бүлгийг сонирхох дуртай болов гээд асуухад нь, алдар богд Жангар хаан таалал болсон уу, үгүй юү Тамга ширээгээ хүнд өгсөн үү үгүй юү гэж асуудаг. Нэртэй жангарч Шишнээн Буурал, сахлаа имрэн хуйхаа маажгаад: - За тийм бодоход одоо би ‘Алдар ноён Жангар хаан таалал болохдоо Алтай зуугийн арслан тамгаа Хошуунулаанд өгсөн бүлэг’-ийг хэлсү би гэж энэ бүлгийг Цагаан гэгээнд хэлсэн гэдэг. Тэгээд Ховогсайрын Оржаа вангийн тамгын бичээч Замадаг гэдэг хүн тус бүлгийг бичиж, ‘Жангар’-ыг судар болгож гэнэ. Ачит багш минь ээ, энэ ‘Жангар’-ын бүлгийг манай нутгийн ноён сайд одоо нутагтайгаа тийм дээд биширдэг тул миний бие нэртэй жангарч Эрхэтэй гэдэг өвгөнөөс уншсу гэж сурахул минь, ‘Алтан-гэрэл’ мэт ороолготой ‘Жангар’-ын энэ судрыг надад өгсөн билээ. Бийр янтай, бэх цаасан үгүй болж, хайж ядаад эвлэж байгаад энэ мэтийн байдлаар бичив би, миний бие шар ногтны адуунд явдаг болов би, адгамтайгаар танд илгээв би, шүүж үзэгтүн, энэ ‘Жангар’-ын төгсгөлд нь номын зүрхэн гэдэг үгүүдийг бичсэн байна. Түүнийг нутгийн хүмүүс ба лам хувраг хүмүүс Кадан болгон биширдэг билээ. Түүнийг бас ард нь бичив би, үгийн утга нь мэдэгдэхгүй, Жангарын Зээг гэж жангарч Эрхэтэй эхлэн хэлдэг билээ. ...Хулгана жилийн үр сард Бөөдэйн хөвгүүн шавь Өлзийт бичив” (Жангарын эх материал, 1988:745) гэж Цагаан гэгээний сануулгаар тус бүлгийг Шишнээн Буурал хэлж, Замадагийн бичсэн “Жангар” нь Жуунайны өвөг аав болох Эрхэтэйд байснаас Өлзийт гүздэй хуулж бичсэнийг өгүүлсэн байна.

4. “Догшин шар мангасын бүлэг”-т “Өвөг ээж Эрхэтэйн Монцог гэх эмэгтэй жангарч надад зааж хүмүүжүүлсэн Жангар билээ, 1932-жилийн барагт” (Таяа, 2006) тус бүлгийг өөрийн өвөг ээж Монцогоос сурснаа бичсэн байна.

5. “Эзэн манширын хаан дэлхийн эрдэнэ ширээ эзлэн сайхарсан эзэн богд нарын үе дарааны сүлжээс” бүлэгт “Ээ! Багш минь, энэ ‘Жангар’-г манай нутаг тийм сонин дээдээр биширнэ, тэр тул сэтгүүрийн төлөө сэдвэр болгоод судар номоос хуулж би, шавь Өлзийт Бөөдэйн хөвгүүн, хулгана жилийн үр сард”(Жангар, 2000) гэж тус бүлгийг хэн хэзээ бичсэнийг тодорхойлжээ.

6. “Алдар торц хааны төрлүүд Мэргэн торц хааны ачууд Манхан магнай тариачин аавын үр үлдэрүүдийн үе дарааны сүлжээс”-т “Ачит багш минь ээ,

танай даалгасан зааврын ёсоор сэтгүүрийн тархийн сэдвүүр гээд сэдэн таньсан шинж чанараар, бие хэмээн сэтгэлээсээ биширсээр, Цагаан гэгээний өлмийн дэргэд, Ховогсайрын нутаг, хуучин торгуудын нэртэй жангарч нар, ийн хэмээн хэлснийг гэрээслээд, Чин вангийн тамгын бичээч, Замадагийн бичвэрээс бичив би, ачтай багш шүүж үзэхийг өчүүхэн сэтгэлээсээ гуйна би, шавь Өлзийт Бөөдэйн хөвгүүн, хулгана жилийн үр сар арван гуравтайдаа бичив” (Жангар-3, 2000) гэж хэний даалгавраар хэн бичсэнийг, хэн хэзээ бичсэнийг тодорхойлон бичсэн байна. Энэхүү дээрх хоёр бүлэг нь үнэндээ нэг л бүлэг байж, “Жангар (3)”-т оруулан хэвлэхдээ салгаж нийтэлсэн байна. Энэ бүлэг нь чухамдаа 140-120 жилийн өмнө Замадаг сударлан бичиж, Бөөдэйн Өлзийт 1912 он буюу хулгана жил бичсэн байна. Бөөдэйн Өлзийтийн бичсэн судрыг Жуунай хадгалж байснаа ХХ зууны наяд оны сүүлчээр Жа.Батнасанд өгсөн байдаг (Батнасан, 2015). Иймээс энэ бүлгийн сүүлд гарах сураг занги нь үнэндээ Жуунайны бичсэн биш, харин Замадагийн бичсэн сураг занги болох үнэн.

Зарим эрдэмтэд энэхүү мэдээг гүйцэд ойлгохгүйгээр жангарч Жуунай “хуурамч ‘Жангар’ зохиож, худал баримт хэлж байгаа явдал нь эрдэмтдийг буруу замд оруулж, ‘Жангар’-ын судлалыг төөрөгдүүлж, аль болох зүй бус дүгнэлт гаргахад хүргэж байсныг илчлэн тэмдэглэх цаг болсон биз” (Эрдэнэбаяр, 2010: 52) гэж ямар ч баримт үгүйгээр гүтгэн бичсэнийг Ж.Жуунайны энэхүү хавсаргасан зүйл нь “хүмүүсийг хуурах хуурамч баримт” бус, харин үнэн бодитой зүйл болох нь тодорхой байна (Бу.Мөнх, 2015) гэж эрдэмтэд удаа дараа нотолсон байдаг. Гэтэл жангарч Жуунайгаас өөрийн адилхан нэг гар бичмэлдээ Замадагийн бичсэн сураг зангийг бичсэн үгүй болохоор (Таяа, 2006:13) зарим эрдэмтэд “Жангар (3)” номд орсон ижил бүлэгтэй харгуулж нягталж үзэхгүйгээр “Жангарын сайн сонсогч нар гээд энэхүү харийн элементийг сайн сонсож гарахгүй хэмжээнд хүртэл амьдлагаар ургуулан зохиогоод, ‘эзэн Манширын эрдэнэ ширээ’ болгосон” (Зуланцэцэг, 2013: 91) гэж, “эзэн Манширын эрдэнэ ширээ”-г Жуунай зохиосон гэсэн нь бодит байдалд үл нийцэх судалгаа болсон байна. Тиймээс жангарч Жуунайны “Жангар”-ын төгсгөлд бичсэн зарим хавсралт сураг зангийг нягтлан судлах нь судалгааны зарим буруу ташаа дүгнэлтээс зайлсхийж чадах судалгааны маш үнэ цэнтэй зүйл юм.

7. “Догшин шар Гүргүүгийн бүлэг”-т “Жавын Жуунай тэмдэглэн бичив. 74 насандаа 1999.8.1. Энэ Жангар болбол Ижилд байхад Халиун гэдэг нэртэй жангарч бичгийн эрдэмтэн биеэрээ зохиож, далан төдөг цолтой Төрбаяр өвгөн, Түвшинжаргал эмгэнээс бичиж авсан гэсэн баримт байна. Оржай вангийн үед Эрхэтэй залгасан түүхтэй. Орлогожавын үед Өлзийт гүздэй дэвтэрлэсэн, шавь надад номлон заасан. Миний эцэг Жав Салхитын наранд агнаж байгаад надад улаан махан цээжээрээ зоог ааг болгон ярьдаг байсан ажээ. Одоо би залган бодвол үнэ цэнтэй болохоор үг бүр нь ончтой. Өгүүлбэр бүр нь онолтой. Чухал болох нь үзэгдэнэ. Өөц болгохийг хүсье” (Таяа, 2006: 13) гэж энэхүү бүлгийн уламжлалын цаг нь нэлээд эрт, Халиун Төрбаяр өвгөн, Түвшинжаргал эмгэнээс бичиж авсан. Оржай вангийн үед Эрхэтэй залгаж, Орлогожавын үед Өлзийт гүздэй бичиж дэвтэрлэсэнээ Жуунайд заасан гэдэг. Түүний эцэг Жав ч хэлдэг байсныг бичсэн байдаг.

8. “Арслангийн араг улаан Хонгор Далан хаан лугаа байр булаалдсан бүлэг”-ийн эцэст “Жавын Жуунай 74 насандаа бичиж тэмдэглэв. 1999-8-1 нд үр сад ба үе залгагч нарт ашиглахыг сануулья, би! Энэ бүлэг бол миний багш Өлзийт гараараа бичсэн 32 бүлэг Жангар дотор чухал гэсэн таван бүлгийн нэг нь юм. Харамсалтай нь 1966-жил Ван ноёны Өлзийт гүздэйн үлдээсэн зэвтэй хадаасан хэцээр, дөрвөн хуучны нэгэнд түймэрдээд хаясан байж билээ. Энэ бүлэг бол Таван чухлын нэг нь билээ. Анх төөмжилсөн хүмүүс бол Төрбаяр өвгөн ба Түвшинжаргал эмгэн хоёр юм. 1632 онд ижилд бичгийн эрдэмтэн нэртэй жангарч Халиун данслан бичиж, Ховогийн түүхэнд дансалжээ! Ховогт нүүж ирсэн Цэвэгдоржийн асруут хөвгүүн Доржраш (нутаг Оржай ван гээд дуудмуй) Вангийн цаг үед Шишнээн Буурал, Эрхэтэй нар залган хэлсэн түүхтэй! Орлогжав Вангийн цагт тамгын бичээч Өлзийт гүздэй 32 бүлэг бичин данслаад тараасан түүхтэй юм! Одоо миний бие Жунгоогийн амьд хоцорсон жангарч болсны хувиар чухал таван бүлгийг, санаандаа байснаа залгамжлахыг дуртай үзэж баймуй! Чухал таван бүлгийг тэдний хэлсэнд үндэслэвэл үг бүр нь агуулгатай, үнэтэй цэнтэй. Өгүүлбэр бүр нь онолтой, гүн ухааны шинжтэй байх нь мэдэгдэмүй!” (Тайван, 2023: 103-104) гэж энэхүү бүлгийн уламжлалыг Халиун бичиж, Доржраш вангийн үед Шишнээн Буурал, Эрхэтэй нар хэлж, Орлогжав вангийн үед Өлзийт гүздэй бичигт буулгасан тухай мэдээг бичиж үлдээжээ.

Одоо бидэнд мэдэгдэж байгаагаар жангарч Жуунай бол “Жангар”-ын уламжлал, жангарч, “Жангар”-г бичигт буулгасан бичигчтэй холбогдох чухал мэдээг тэмдэглэж үлдээсэн цорын ганц жангарч юм. Энэ нь XX зууны тавиад оноос өмнөх жангарч болон уламжлалд холбогдох маш чухал үнэтэй мэдээ болно.

## 2. Хавсралт сураг зангид гарах хүмүүсийн тухай

Жуунай “Жангар”-ын хавсралтад гарах хүмүүс нь голдуу ноён хутагт болон жангарч бичээч болно. Үүнд: Халиун, Шишнээн Буурал, Эрхэтэй, Монцог, Төрбаяр, Түвшинжаргал, Жав зэрэг жангарч байжээ. Мөн Замадаг, Өлзийт гүздэй зэрэг бичээч нар байжээ. Оржай ван, Доржраш, Орлогожав зэрэг ноёд, Цагаан гэгээн гэх хутагт хүмүүс гардаг юм.

### (Нэг) Жангарчид

Жуунай “Жангар”-ын зарим бүлгийн төгсгөлийн хавсралт сураг занги дахь Төрбаяр өвгөн болон Түвшинжаргал эмгэний тухай одоо домгийн уламжлалаас өөр дэлгэрэнгүй тэмдэглэл байх үгүй учраас эрдэмтэн Д.Таяа “домгийн жангарч” (2015: 50) хэмээн тэмдэглэсэн байдаг. Бусад жангарчдын тухай Жуунай ч “Монголчуудын түүхээс чухал тэмдэглэлүүд-Халиун жангарчийн материалууд”(Тайван, 2015: 83), “Халиуны дөхөм намтар” (Тайван, 2015: 90), “Халиуны гэрээс”(Тайван, 2015: 95) зэрэг тэмдэглэлийг бичиж үлдээснээс гадна олон эрдэмтэд хээрийн судалгааны материалдаа тодорхой тэмдэглэсэн байдаг. Тэгвэл жангарч Жуунай тэмдэглэл болон бусад материалд үндэслэж эдгээр жангарч болон бичээч нарын тухай товчхон өгүүлэхийг зорив.

1. Халиун бол Ховогсайрын гэхэрэн гэдэг овгийн Зуваг-Улаан баатрын ууган хөвгүүн болох бөгөөд одоогийн алдарт жангарч Жавын Жуунай хуланц өвөг юм. Тэрээр 1630 онд Хоо-Өрлөгийн дагуулгаар Ижил мөрөнд нүүж очсон хуучин торгуудын “далан төдөг (товч)” цолтой алдарт жангарч Төрбаярын зургаадугаар үеийн хүн байсан бөгөөд нэлээд ядуу амьдралтай байсан болохоор “Жангар” хэлээд гэдсээ тэжээдэг байжээ. Тэр 70 бүлэг “Жангар”, 23 бүлэг “Гэсэр”, 40 бүлэг мичин багшийн үлгэр (баруунш зорчсон тэмдэглэл), Чингисийн 10 бүлэг зэргийг мэдэхээс гадна “Арж Борж хааны тууж”, “Наран далай хааны түүх”, “Хөх арцан”, “Сэрж богширгын тууж”, “Шагжамуни ологсод бурхан багшийн даяан бясалгасан шоогийн дүн” ... мэтийн үнэтэй цэнтэй судар номыг туурвин бичээд Ар их нутагтаа хоцроосон эрдэмтэн жангарч мөн гэдгийг бичиж үлдээсэн түүхтэй. Тэр 1779 онд Ховогсайртаа нүүж ирээд 88 насандаа өнгөрөв гээд их зүүн суман тоочин тэмдэглэдэг юм (Тайван, 2015:91) гэж алдарт жангарч Жуунай тэмдэглэжээ. Германы жуулчин Бергман “1771 онд Торгуудууд Шинжаан руугаа буцахаас өмнө Ижил мөрний халимаг ханы харьяат болох Цэвэгдорж гэдэг ноён байсан бөгөөд түүний албатуудынх нь дунд нэгэн шалгарсан жангарч байжээ. Цэвэгдорж ноён үргэлж жангарчаа дагуулан Убаши ханы ордонд очиж ‘Жангар’ хайлуулдаг байжээ. Тэр жангарч хэдэн өдөр үргэлжлүүлэн олон бүлэг ‘Жангар’ хайлж, сайд ноёдын шагналыг авдаг байв. 1771 онд Убашийн харьяат торгуудууд Ижил мөрнөөс Алтайн орчимд буцахдаа сайд ноёд нь тэрхүү шалгарсан жангарчаа ч авч явсан гэнэ” (Кичгэ Төлө, 1974:43) гэх тэмдэглэлд үндэслэж, эрдэмтэн Д.Таяагаас “Бергманы тэмдэглэсэн Ижил мөрнөөс Алтайн орчим буцаж ирсэн Ижил мөрний торгуудын нэртэй жангарч гэдэг нь даруй Цэвэгдорж ноёны дуудлагаар Ижил мөрнөөс Алтайн энгэрт байрлах Ховогсайр гэх газарт буцаж ирсэн үнэн сүсэгт хуучин торгуудын хойд замын чуулганы Халиун гэдэг жангарч байсан шиг байна” (Таяа, 2015: 57) гэж үзсэн байна.

2. Шишнээн Буурал бол Ховогсайрын дунд хошууны бага зүүн сумын хүн бөгөөд унах морьтой, саалийн үнэтэй энгийн нэг ядуу малчин байжээ. Тэр XIX зууны дунд үеэс эхэлж нутгийн жангарчдаас “Жангар”-ыг суралцсан бөгөөд XX зууны эхэн үе хүртэл “Жангар” хайлж явсан байна. Буурал 36 бүлэг Жангар мэддэг байжээ. Доноровцэрэн чин вангийн тусгай жангарчаар залагдаж, Тарвагатайн шийхэв амбаны заллагаар Тарвагатайд очиж “Жангар” хайлж алт, мөнгө, артай торгоор шагнагдаж байжээ. Ховогсайрын баруун хойд биед Сайрын уулын ар үзүүрт “Бууралбай” гэдэг нэртэй нэг салаа байдаг ажээ. Тэр салаа бол алдарт жангарч Шишнээн Бууралын өвөлжөө байжээ. Тэгээд түүнээс хойших үеийн ван ноёд тэрхүү алдарт жангарчийг дуурсгахын төлөө түүний өвөлжөө “Буруулбай (овоо)” гэж нэрлээд, чулуугаар овоо босгоод дуурсгасан гэдэг. Орлогжав чин вангийн тусгай жангарч байсан бөгөөд 32 бүлэг “Жангар” хэлдэг. Мөн алдарт жангарч Халбир Баяр бол Шишнээн Бууралын шавь нь байсан (Батнасан, 1983) гэдэг.

3. Эрхэтэй бол икэл, бийв, товшуур цохиж “Жангар” хайлдаг байсан бөгөөд энэ бүх эрдмээ хөвгүүн Жавдаа сургасан гэдэг. Түүний өвөг аав Эрхэтэй болон эцэг Жав бол хоёр үеэрээ ван ноёнд хайрлагдаж ирсэн жангарч, цэнгэлч хүмүүс



байжээ (Батнасан, 1983). Эрхэтэйн эмгэн Монцог ч жангарч байсан эсэх талаар мэдээлэл байхгүй байна.

4. Жав (1900-1945) цагаан хулгана жил 1900 онд үнэн сүсэгт хуучин торгуудын хойд замын чуулганы вангийн хошууны их зүүн сумын ядуу малчин Эрхэтэйн гэрт төржээ. Тэр 13 бүлэг “Жангар” мэддэг бөгөөд икэл, бийв, товшууртай хөгжимдөж, хошин шог маягаар “Жангар” хайлдаг хүн байжээ. Тэр хөгжимд их авьяастай икэл, бийв татаж, лимбэ, цоор үлээж, ятга, товшуур цохидог байсан бөгөөд мөн дуу сайхан дуулдаг болохоор, ван ноёдод таашаагдаж, жангарчийн хувиар биш, цэнгэлчийн хувиар тухайн үед Орлогожав вангийн эрхэн сайн цэнгэлч буюу хөтөч нь болж яваад 1945 онд нас баржээ (Батнасан, 1983).

### (Хоёр) бичээч нар

Алдарт жангарч Жуунай багшийнхаа тухай “Бөөдэйн Өлзийтийн дөхөм намтар”( Батнасан, 1983), “Өлзийт гүздэйн гэрээс”(Батнасан, 1983) зэрэг гар бичмэлийг бичиж үлдээсэн боловч Замадагийн тухай эрдэмтэн Ж.Батнасангийн зохилоос өөр тэмдэглэл үгүй байна (Батнасан, 1983).

1. Замадаг бол 1870 оны үед үнэн сүсэгт хуучин торгуудын хойд замын чуулганы вангийн хошууны бага баруун сумын малчин Донровын гэрт төржээ. Тэр тухайн үед нэлээд бичиг үсэгтэй хүн байсан болохоор Доноровцэрэн чин вангийн тамгын бичээч болж байжээ. Тэр тамгын бичээч байхдаа Шишнээн Бууралын хэлдэг “Жангар”-ын бүлгийг бичиж тэмдэглэсэн бөгөөд 1900-ээд оны өмнө буюу хойно “Жангар”-ын үе сүлжилтэй холбогдох “Алдар торц хааны ач, Мэргэн торц хааныхны уг тохмын сүлжээс” гэх шастир цадигийг тухайн үеийн Шишнээн Буурал зэрэг алдарт жангарчдаас анх тэмдэглэж үлдээсэн байна. Замадагийн хэзээ нас барсан тухай тодорхой мэдээ байхгүй. Ж.Батнасангаас “Замадагийн хөвгүүн Сангаж (хонин жилтэй) гэдэг хүн 1969 оны 3 сарын 20-нд 75 настайдаа нас баржээ. Ингээд бодохоор Сангаж хөхөгчин хонин жил (1895)-д төрсөн байна. Сангаж ач нартаа миний 18 настайд аав нас барсан гэж хэлснээс үзвэл Замадаг 1912 онд нас барсан байна” гэж бичсэн байна. Замадаг бичээч Гомбожав, Сангаж, Өлзийт гэдэг гурван хөвгүүнтэй байсан бөгөөд тэдний дотроос Сангаж (1895-1969) гэлэн гэдэг хүн нэртэй задач хүн байжээ (Батнасан, 2015).

2. Өлзийт гүздэй (1899-1944/1945) бол Ховогсайрын Вангийн хошууны их зүүн сумын Бөөдэй гэдэг ядуу цахар айлд 1899 онд (гахай жил) төржээ. Тэрбээр өөлдийн Батчулуун үхэрдэйгээс Доноровцэрэн вангийн хүү Орлогожавын хамт тод бичиг заалгаж сурсан байдаг (Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ 1992: 121). Жангарч Жуунай “Бөөдэйн Өлзийтийн дөхөм намтар” гэх гар бичмэлдээ “хорин долоон наснаасаа дөчин дөрвөн нас хүртлээ Орлогожав вангийн тамгын бичээчийн алба хашиж” гэж бичсэнээс үзэхэд, 1926 оноос эхлэн вангийн тамгын бичээч болжээ. Орлогожав ван, Чойжав ван зэрэг хоёр вангийн тамгын бичээч болж, 19 жил энэхүү үүргийг хашсан байна. Жуунай “Өлзийт гүздэй 1944 оны өвөл 45 насандаа өвчнөөр нас барав” хэмээн тэмдэглэсэн байдаг.

Ж.Батнасангаас: “1944 оны 5 дугаар сард Өлзийт гурван аймгийн засгийн талд баривчлагдаад, 1945 оны 2 дугаар сард харьж ирээд, удалгүй хамраас нь цус гоождоод зогсоож чадалгүй гэртээ хэдэн өдөр болоод нас барав”(Батнасан, 1983) гэжээ. Юу ч гэсэн Өлзийт гүздэй 1944 оны сүүлч, 1945 оны эхээр нас барсан байна. Өлзийт гүздэй бол түүх соёлын холбогдолтой ном судрыг их эрхэмлэн нандигнан бичиж сударлан, арвин их бичмэл судар, түүх, утга зохиолын холбогдолтой судар бичгийг ч нэлээд олныг хадгалж байсан ба мөн баатарлаг тууль “Жангар”-ын уламжлал, хөгжилд ихээхэн хувь нэмэр үзүүлсэн хүн юм. Өлзийт гүздэй тухайн үед алдарт жангарч Холбир Баяр, Шарын Насан зэрэг хүмүүсийг гэртээ залж авчраад “Жангар” хэлүүлж, өөрөө бичиж 32 бүлэг “Жангар”-ыг Шарын Насан бичиж, Өлзийт гүздэйд бэлэглэсэн 8 бүлэг “Жангар”-ын эх бичмэлийг хадгалж байжээ. 1940 оны өвөл дунд хошууны Өлзийт гүздэйгээс Шарын Насаныг залж ирүүлээд “Жангар”-ыг хэлүүлсэнд тэр хэдэн шөнө залгуулан бийв татаж “Жангар” хайлсныг Жуунай сонсож байжээ. Өлзийт гүздэй гагцхүү “Жангар”-г бус, “Гэсэр”, “Тэржэй богширгын зулзага Сэржэй богширгын тууж” болон бусад аман зохилын төрлүүдийг ч хүндэтгэн бичиж, сударлан шавь нараараа цээжлүүлдэг байв. Тод үсгээр бичигдсэн “Торгууд хаадын тууж”, “Баатар Убаши түмний туурвисан дөрвөн ойрадын түүх”, “Үнэн сүсэгт хуучин торгууд хойд аймгийн ван гүнгийн засаг тайж нарын уг эхний нэр данс”, “Үнэн сүсэгт хуучин торгуудын хойд замын чуулганы дарга засаг зоригт хаан Буянцогтын тохом уг язгуурын шадар төрлийн дэвтэр”, “Торгуудын уг язгуур” зэрэг ойрад түүхийн чухал сурвалж бичгийг ч Өлзийт гүздэй өөрөө болон өөрийн шавь, улаач нараараа бичүүлж хадгалсан нь өнөөдөр бидний судалгаандаа ашиглаж байгаа түүхийн ховор үнэ цэнтэй материалууд юм (Тайван, 2012: 226).

### (Гурав) Ноёд болон хутагт нар

“Үнэн сүсэгт хуучин торгууд хойд аймгийн ван гүн засаг тайж нарын уг эхний нэр данс”(Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ, 1992: 121), “Монголын хошуу нутгийн тэмдэглэл” (Жан мо, 1992), “Хуучин торгууд хойд аймгийн уг эхэн үе ба Тарвагатайн харьяат монгол нутгийн зан байдал” (新疆维吾尔自治区档案局(馆)编, 2017) зэрэг сурвалж бичигт үнэн сүсэгт хуучин торгууд хойд аймаг болох Ховогсайрын ван ноёдын он дарааллыг тэмдэглэсэн ч тэдний “Жангар” буюу жангарчдын “Жангар”-г сонсож байсан тухай албаны тэмдэглэл одоо болтол олдоогүй байна. Харин жангарч Жуунай бичсэн хавсралтад Донровцэрэн ван, Орлогожав ван, Доржраш нарын нэр дурдагдаж байгаа нь тухайн бүлгийн бичигдсэн он цагийг тодорхойлох тодотголын үүрэг гүйцэтгэж байна. Энэ нь ван ноёд “Жангар”-г хүндэтгэсэнгүй гэх үг биш, харин ван ноёд хүндэтгэсэнээс сая тэдний бичээч нар “Жангар”-г хүндэтгэн сударлан тэмдэглэж байсан юм. Харин Цагаан гэгээн бол “Жангар” сонсож байсныг тодорхой тэмдэглэсэн байдаг. Цагаан гэгээн төвөд хүн байсан бөгөөд хөхөгчин модон хонь жил буюу 1835 онд мэндэлжээ. Улмаар хар усан хулгана жил буюу 1852 онд 18 настайдаа Алтай, Ховогсайр, Тарвагатайн газар орноор анх залран ирсэнд, ард түмэн “Цагаан гэгээн” гэж хүндэтгэн нэрлэжээ. Манж,

монгол, хятад хэл бичигт нэвтэрсэн хүн байжээ. Тэр удалгүй нутагтаа буцаж ирээд, 1863 онд дахин Шинжаанд ирж Тарвагатайд суусан ажээ. Цагаан гэгээн 1864-1870 оны хооронд Ховогсайрын чин вангийн ордонд олон удаа ирж байсан (Батнасан, 2015) гэдэг. Цагаан гэгээний “Жангар” сонсож байсан тухай Жуунай бичсэн хавсралтын сураг зангийн тэмдэглэлээс гадна эрдэмтэн Ж.Батнасан ч өөрийн байцаалт тэмдэглэлдээ “Чин вангийн ордонд Шишнээн Бууралаар Цагаан гэгээн ‘Жангар’ хэлүүлж гэнэ. Шишнээн Буурал ямар Жангарын бүлэг хэлэх вэ? гэхэд ‘Бор магнайн бүлгийг хэл’ гэжээ. Түүнийг сонсож дуусаад Цагаан гэгээн ‘Сайн хэлэв чи, гагцхүү дайны хөлд малиагаа алдаж орхиод гэдрэг эргэж ирээд малиагаа олж авсныг хэлсэнгүй чи, бусдыг нь бүрэн хэлэв чи’ гэжээ. Шишнээн Буурал Цагаан гэгээнд Жангар хэлж, өдөр шөнө залгаж, хэдэн өдөр хэлээд ирэхэд, “Жангарынхан хоол иддэггүй нутаг уу?” гэж Цагаан гэгээн асуужээ. Тэгэхэд Буурал нэгэн цагт ирээд уулын чинээ гурил элдээд, урт шар будаагаа татаж, олон бугын мах чанаад, одоо Жангарынхан будаалж байна гэж хэлсэн гэдэг”(Батнасан, 2015) хэмээн тэмдэглэсэн байдаг.

Дээрхийг хураангуйлан өгүүлэхэд, Жуунай “Жангар”-ын зарим бүлгийн төгсгөлд бичсэн хавсралт сураг зангид гарах хүмүүсийг эрдэмтэн судлаачдын байцаалт, судалгаагаар баталсан үнэн бодитой сураг занги байж, харин зарим эрдэмтэн судлаачдын бичсэн “Жа.Жуунай энэхүү хулгайлж зохиосон хуурамч бүлгийнхээ эцэст хавсаргажээ. Тухайн хавсралт зүйлдээ хүмүүсийг хуурах хуурамч баримт” зохиосон явдал огт биш, харин ч бидний цаашид судлах судалгааны үнэ цэнтэй сэдэв юм.

### 3. Хавсралт дахь сураг зангийн үнэ цэн

Өмнө өгүүлсэн жангарч Жуунай “Жангар”-ын зарим бүлгийн төгсгөл дэх хавсралт сураг занги нь Жуунай “жангарч гэсэн сайхан нэр ба эд мөнгөний ашиг тус олохын төлөө” зохиосон зүйл биш байжээ. Харин ч түүх, соёлын үнэ цэнтэй зүйлс болох юм. Үүнд:

1. Ховогсайрын торгуудад “Жангар”-ын уламжлал байсныг гэрчилж байна. Үүнд: Халиун, Шишнээн Буурал, Эрхэтэй, Монцог, Төрбаяр, Түвшинжаргал, Жав зэрэг дотоод, гадаадад нэр алдартай жангарчид байснаас “Жангар”-ын уламжлал улам батжиж, өнөөдөр бидэнд уламжлагдаж ирсэн юм. Үүнд: Халиуны тухай Халимагийн түүхийн баримт материал гарч ирвэл жангарч Жуунай хавсралт сураг зангийн үнэ цэнийг улам нэмэгдүүлж, дараа дараагийн судалгаанд анхаарах ёстой судалгааны сэдэв болно.

2. “Жангар”-ын уламжлал нь эртнээс өнөөг хүртэл хаад ноёд, хутагт хувилгаад буюу албаны талын дэмжлэгээс огтхон ч салж үзээгүй юм. Эдгээр дээд давхаргын дэмжлэг хүчтэй болох тутам “Жангар”-ын уламжлал улам хүчтэй дэлгэрч байжээ. Жангарч Жуунай хавсралт сураг занги дахь Оржай ван, Орлогожав ван, Доржрашын нэр дурдагдсан нь тэдний хүндэтгэл зарлигаар бичээч нар нь бичиж сударласныг мэдүүлж байна.

3. Бичгийн уламжлал нь аман уламжлалыг бодвол харьцангуй удаан үргэлжилдэг. Тиймээс бичигтэй хүмүүс “Жангар”-г сударлан бичиж, үеийн үед уламжлан үлдээхийг хүсэж байжээ. Үүнд: хавсралт сураг зангид гарах Замадаг, Өлзийт гүздэй зэрэг бичээчийн сударлан бичсэн “Жангар”-г жангарч Жуунай хадгалан үлдээсэн буюу бичиж, бидний үед авч ирсэн нь жангарч Жуунай дэлхийн соёлын өв санд үлдээсэн хамгийн том гавьяа юм. Үүнд: “Алдар торц хааны ач, Мэргэн торц хааныхны уг удмын сүлжээс” гэх бүлгийн уг эх” (Батнасан, 2015), “Алдар ноён Жангар хаан алтай зуугийн арслангийн тамгаа Хошуун-Улаанд өргөмжилсөн бүлэг” (Жангарын эх материал. Ес, 1988: 649), “Хоёр настай Хошуун-Улаан хөл өргөж дайнд мордоод Догшинцагаан хааныг доройтуулсан бүлэг” (Жангарын эх материал ес, 1988: 649), зэрэг бичиж цээжилсэн бөгөөд эдгээр бүлгийг өөр жангарчид хэлээгүй байсан ажээ.

4. Жангарч Жуунай бол удамтай жангарчаар барахгүй бичигтэй жангарч байсан юм. Ахмад үеийн бичээчид болох Замадаг, Өлзийт гүздэй нарын “Жангар”-г сударлан бичиж үлдээж байсан сайхан уламжлалыг мөрдөж, тэднээс үлдсэн судар буюу өөрөө олон бүлэг “Жангар”-г бичиж үлдээсэн нь “Жангар”-ын уламжлалыг улам баяжуулжээ. Энэхүү олон бүлгийн дотор бусад жангарчдийн хэлээгүй буюу мэддэггүй олон бүлэг “Жангар” байсан нь одоо бидэнд ил болсон. Тиймээс жангарч Жуунай бичсэн “Жангар” нь “хуурмаг Жангар” бус, харин ч эртний уламжлалтай “Жангар”-ын бүлэг болохыг тодорхой баримтаар баталж байгаа юм.

### Дүгнэлт

Жангарч Жуунай “Жангар”-ын зарим бүлгийн төгсгөлд бичсэн хавсралт сураг занги нь “Жангар”-ын уламжлалын тухай маш их үнэ цэнтэй сураг зангийг хангаж байгаа боловч энэ тухай тусгайлсан судалгаа хийгдээгүйгээс болж, зарим эрдэмтэд хавсралт сураг зангийг утга агуулгын хувьд зориуд гуйвуулж, “жангарч гэсэн сайхан нэр ба эд мөнгөний ашиг тус олохын төлөө” зохиосон буюу эсгэж “эзэн Манширын эрдэнийн ширээ”-г Жуунай зохиосон гэж үзсээр ирэв. Гэтэл эдгээр нь ямар ч баримт нотолгоогүй байгаа юм. Жуунай зохиогоогүй, харин эртний уламжлалтай байсан гэдгийг гэрчилж байна. ХХ зууны тавиад оноос өмнөх жангарчид, “Жангар”-г сударлан бичигч, хаад ноёд, гэгээн хутагт нар “Жангар”-г хэрхэн хүндэтгэлтэй хандаж байсныг гэрчлэх түүх, соёлын үнэ цэнтэй сураг зангийг хангасан бөгөөд хойшид нарийвчлан судлах хэрэгтэй байна.

## Ном зүй

## А. Монгол хэлээр:

Кирилл бичгээр

**Эрдэнэбаяр, Ж.** (2010). *Жангарын тархац түүний газар зүйн хэв шинжүүд*. Улаанбаатар:

Монгол бичгээр

**Батнасан, Жа.** (1983). *Ховогсайрт 'Жангар' уламжлагдаж ирсэн тухай байцаалтын мэдүүлэлт*. Өвөр Монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, нэгдүгээр хугацаа.

**Батнасан, Жа.** (2015). “*Жангар’ тууль бол эртний түүх дэх үнэн бодитой хүмүүсийн дүр болох тухай туршин өгүүлэх нь*”. - Баруун хойдын Үндэстний Их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, нэгдүгээр хугацаа.

**Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ,** (1992). *Ойрад түүхийн дурсгалууд*, Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо:

**Мөнхөө, Бу.** (2015). *Ж.Жуунайн Жангар судлал*, Шинжааны ардын хэвлэлийн хороо:

**Бу.Мөнх,** (2015). “*Ж.Жуунайн 'Жангар', Шинжаанын ардын хэвлэлийн хороо, 2015 оны 12 сар.Р.123. бас Жа.Батнасан: “Жангар” тууль бол эртний түүх дэх үнэн бодитой хүмүүсийн дүр болох тухай туршин өгүүлэх нь*”, “Баруун Хойдын Үндэстний Их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл”, нэгдүгээр хугацаа.

**Таяа, Д.** (2015). *Жангарчийн судлал*, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо:

**Жуунайн гар бичмэл Жангар,** (2006). Д.Таяа буулган дэглэв, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

**Жангар-3,** (2000). Шинжааны ардын хэвлэлийн хороо:

**Жангарч Жуунайн гар бичмэл Жангарын шинэ олдвор,** (2023). О.Тайван цуглуулан буулгаж тайлбарлав. Шинжаан Их сургуулийн хэвлэлийн хороо:

**Жангарч Жуунайн гар бичмэл текст (нэг).** (2015). О.Тайван цуглуулан буулгаж тайлбарлав, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо:

**Тайван, О.** (2012). “*Үнэн сүсэгт хуучин торгуудын хойд замын чуулганы хамгийн сүүлчийн вангийн тамгын бичээч Өлзийт гүздэйн тухай*”, “*Цээжин судар-Ховогсайрын торгуудчуудийн аман соёлын өв (нэг)*”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо:

**Тайван, О.** (2015). “*Жангарч Жуунайн гар бичмэл текст (нэг)*”, цуглуулан буулгаж тайлбарлав: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо:

**Тайван, О.** (2023). “*Жангарч Жуунайн гар бичмэл 'Жангар'-ын шинэ*

*олдвор*”, цуглуулан буулгаж тайлбарлав: Шинжааны Их сургуулийн хэвлэлийн хороо:

**Зуланцэцэг.** (2013). “*Жуунайн Жангар’ дахь ‘Эзэн Манишрын эрдэнийн ширээ’-ний ирлийг шинжлэх нь*”, “Өвөр Монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл”, 2013 оны хоёрдугаар хугацаа.

**Жан мо,** (1992). “*Монголын хошуу нутгийн тэмдэглэл*”, Үндэстний хэвлэлийн хороо:

**Жижэйн Эрдэнэбаяр** (2010). *Жангарын тархац түүний газар зүйн хэв шинжүүд*, Улаанбаатар:

Тод бичгээр

**Жангарын эх материал ес.** (1988). Дундад улсын ардын аман зохиол урлагийг судлах нийгэмлэгийн Шинжааны Уйгар өөртөө засах орны салаа нийгэмлэгээс эмхэтгэв, Шинжааны ардын хэвлэлийн хороо:

**Жангар,** (2000). Дундад улсын ардын аман зохиол урлагийг судлах нийгэмлэгийн Шинжааны Уйгар өөртөө засах орны салаа нийгэмлэгээс эмхэтгэв, Шинжааны ардын хэвлэлийн хороо:


Халимаг бичгээр

**Жижэйн Эрдэнэбаяр** (2010). “*Жангарын тархац, түүний газар зүйн хэв шинжүүд*”, Улаанбаатар:

**Кичгэ Төлө** (1974). Баатрлг дуулвр Жанһар. Хальмг дегтр һарһач, Элст:

## Б. Хятад хэлээр:

新疆维吾尔自治区档案局（馆）编：“新疆维吾尔自治区珍贵档案文献名录”，新疆文化出版社，2017年。



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.